



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 359

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3, 3.4 дэх заалт, Соёл Урлагийн Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2018 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Соёл Урлагийн Их Сургуулийн албан ажлын хэрэгцээнд зориулан 40,400,000.00 (дөчин сая дөрвөн зуун мянган) төгрөгт багтаан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хавсралтад заасан үндсэн хөрөнгийг олж авахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ням-Очир, Соёл Урлагийн Их Сургуулийн захирал Э.Сонинтогос нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Газрын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн  
...359... дугаар тогтоолын хавсралт



Соёл Урлагийн Их Сургуульд олж авах  
үндсэн хөрөнгө

Д/д	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төсөвт өртөг буюу худалдан авах үнийн дээд хязгаар
				(төгрөг)
1	Эзэмшил газар (Сүхбаатар дүүгийн 10 дугаар хороо, Соёл Урлагийн Их Сургуулийн 2 дугаар байрны эзэмшил газрын урд талд байрлалтай, 273 м.кв талбай бүхий газар)	ш	1	40 400 000,00
<b>Нийт дүн</b>		-	<b>1</b>	<b>40 400 000,00</b> (дөчин сая дөрвөн зуун мянган)